

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон
Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг
баталсан огноо:

Байгууллагын нэр:

Усны газар

Нэгжийн нэр:

Ус ашиглалтын хэлтэс

Албан тушаалын нэр:

Усны барилга байгууламж, төсөл хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Дэс түшмэл, ТЗ-6

Ажлын цаг:

Ажлын өдрийн 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

Баянгол дүүрэг, Чингүнжавын гудамж,
Усны газрын байр

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Усыг хуримтлуулах, усны нөөцийг арвижуулах, зохицтой ашиглах усны талаарх хууль тогтоомж, бодлого, төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, гүйцэтгэлийн үр дүнг хэлтсийн даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

- 1.Усыг хуримтлуулан, зохистой ашиглах талаарх хууль тогтоомж, төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх.
- 2.Голын голдирлыг өөрчлөх, урсацад тохируулга хийх, усны барилга байгууламжийн судалгаа, зураг төсөлд дүгнэлт гаргах.
- 3.Усны мэргэжлийн байгууллагын эрх олгох, сунгах, хүчингүй болгох ажлыг зохион байгуулах.
- 4.Албан тушаалын чиг үүргийн дагуу гүйцэтгэх бусад ажил.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх – Ш
1 дүгээр зорилтын хүрээнд.	1.Гадаргын усны хуримтлал бий болгох, урсацын тохируулга хийх замаар усны нөөцийг нэмэгдүүлэх, шилжүүлэн ашиглах төслүүдийн хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах:	Усыг хуримтлуулахаар барилсан боомтын тоо.	Г.Х
	2.Усны хуримтлал бий болгох дотоод, гадаадын хөрөнгө оруулалттай төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах:	Дотоод, гадаадын хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр.	Г.Х
2 дугаар зорилтын хүрээнд	1.Голын голдирлыг өөрчлөх зураг төсөлд дүгнэлт гаргах:	Гаргасан дүгнэлтийн тоо	
	2.Голын урсацад тохируулга хийх усны барилга байгууламжийн судалгаа, зураг төсөлд дүгнэлт гаргах:	Судалгаа, зураг төсөлд гаргасан дүгнэлтийн тоо.	Г.Х
3 дугаар зорилтын хүрээнд	1.Усны мэргэжлийн байгууллагын үйл ажиллагааны чиглэл, гүйцэтгэх үүргийг боловсронгуй болгох:	Жилд 10-аас доошгүй ААНБ-д эрх олгох, сунгах, усны мэргэжлийн байгууллагын мэдээллийг цахим хэлбэрээр нийтэд мэдээлсэн байна.	Г.Х
	2.Усны мэргэжлийн байгууллагын эрх олгох, сунгах, цуцлах ажлыг зохион байгуулах:		Г.Х
	3.Усны мэргэжлийн байгууллагын бүртгэл хетлэн тайлагнах.		Г.Х



4 дүгээр зорилтын хүрээнд	1.Албан бичиг төлөвлөх, санал бэлтгэх, өргөдөл гомдолд хуулийн хугацаанд нь хариу өгөх;	Албан бичгийн хариу, өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд нь шийдвэрлэсэн байна.	Г
	2.Хурал, зөвлөгөөн, семинарт оролцох, томилолтоор ажиллах;	Хариуцсан ажил үүргийн чиглэлээр дотоод, гадаадын хурал зөвлөгөөнд оролцож, томилолтоор ажилласан байна.	Г

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх.		
Мэргэжил	- гидрогоеологи, инженер.геологи /053204/: - усны барилгын инженер.		
Мэргэшил	Төрийн албаны богино болон дунд хугацааны сургалтад хамрагдаж төгссөн байх.		
Туршлага	Туслах түшмэлийн албан тушаалд ажилласан бол давуу тал болно.		
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	- судалгааны арга зүйн мэдлэгтэй байх; - мэдээлэл дэх дутуу, алдаатай, нийцтэй бус байдлыг илрүүлэх; - гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах; - албан тушаалын чиг үүргээ хэрэгжүүлэхэд учирч болзошгүй эрсдэлийг урьдчилан тооцох, бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх; - нэгжийн дотоод хяналтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд оролцох, үр дүнг тайлагнах; - бусад..	
	Асуудал шийдвэрлэх	- Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулийг чандлан баримталж, үндэсний язгуур ашиг сонирхолд захирагдан ард түмэндээ үйлчилж, төрд чин үнэнчээр зүтгэх; - хууль тогтоомжийн хүрээнд асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулж, үр дагаврыг хариуцах; - шаардлагатай асуудлаар судалгаа хийж, хариуцах; - албан тушаалын бүрэн эрхийн хүрээнд асуудлыг хууль болон ёс зүйн зарчимд нийцүүлэн ашиг сонирхлоос ангид шийдвэрлэх; - асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулж, түүний эзэрэг, сөрөг үр дагаврын талаар удирдлагад танилцуулах. - саналын зөрүү, үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах; - бусад.	
	Багаар ажиллах	- өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж, бусдыг дэмжих, хамтран ажиллах; - бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох; - ажлын цаг ашиглалтын хувьд хамт олныг үлгэрлэх; - багийн зорилго, үйл ажиллагааг ойлгож, дасан зохицож ажиллах; - багийн дунд хүлээсэн үүргээ гүйцэтгэх; - бусад.	
	Бусад	- албан хэрэг хөтлөх, бодлогын баримт бичиг боловсруулах - англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийг ашиглах; - компютерын хэрэглээний программ, мэдээллийн технологийг ашиглах;	МЭДЭЭЛЛИЙН



		<ul style="list-style-type: none"> - бусдад хүндэтгэлтэй, соёлтой, адил тэгш хандах; - монгол бичгээр уншиж, бичих чадвартай байх; - жендерийн тэгш байдлыг хангах.
--	--	--

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьялан удирдах албан тушаалын нэр:

Ус ашиглалтын хэлтсийн дарга.

Албан тушаалд шууд харьялан
удирдуулах албан тушаалын нэр, тоо:

Байхгүй

Нийт: ...

Бусад харилцах субъект

- 1.Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Яам, агентлаг, нутгийн захиргааны байгууллага, бусад төрийн байгууллагын холбогдох албан тушаалтан, албан хаагч;
- 2.Усны мэргэжлийн байгууллага, эрдэм шинжилгээ, судалгааны хүрээлэнгийн холбогдох албан тушаалтан, албан хаагч;
- 3.Олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрийн холбогдох албан тушаалтан, иргэн, хуулийн этгээд.

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг
боловсруулсан:

Албан тушаалын тодорхойлолтыг хянаж,
батлах зөвшөөрөл олгосон байгууллагын
шийдвэр:

Албан тушаал:

Удирдлага, санхүүгийн хэлтсийн дарга

.....
..... О.ГАНТУЛГА
2020 оны 08 дугаар сарын 09.-ны өдөр

Байгууллагын нэр:

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

Шийдвэрийн огноо: 20 09 30

Дугаар: 335

Албан тушаалын тодорхойлолт баталсан:


Байгууллагын нэр:

УСНЫ ГАЗАР

Шийдвэрийн огноо: 2020.12.12

Дугаар: 121

(тамга/тэмдэг)

ДАРГА:  Ш.МЯГМАР

